



## ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС БА ТӨРИЙН ОРОЛЦОО

## THE LEGAL FRAMEWORK AND STATE INVOLVEMENT IN THE PROTECTION OF HUMAN RIGHTS IN THE DIGITAL ENVIRONMENT

Нямдаваагийн Жинжиймаа<sup>1</sup>

University of Internal Affairs, E-mail: [n.jinjiimaa86@gmail.com](mailto:n.jinjiimaa86@gmail.com), <https://orcid.org/0009-0009-4241-2488>

### ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

#### Түлхүүр үгс:

Хүний эрх, цахим орчин, цахим шилжилт, мэдээллийн аюулгүй байдал, төрийн оролцоо

#### Keywords:

Human rights, digital environment, digital transformation, information security, state responsibility

#### Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 10 сар  
Шинэчилсэн: 2025, 10 сар  
Хүлээн зөвшөөрсөн: 2025, 10 сар

#### Article history:

Received Oct, 2025  
Revised Oct, 2025  
Accepted Oct, 2025

### ХУРААНГУЙ

Дижитал эрин үед мэдээллийн технологийн хурдацтай хөгжил нь хүний эрхийн хэрэгжилт, хамгаалалтад шинэ боломжуудыг нээхийн зэрэгцээ урьд өмнө тохиолдож байгаагүй сорилтуудыг бий болгож байна. Цахим орчинд хувийн мэдээлэл алдагдах, үзэл бодлоо илэрхийлэх эрх хязгаарлагдах, цахим ялгаварлан гадуурхалт нэмэгдэх, цахим гэмт хэрэг өсөх зэрэг үзэгдлүүд нь хүний эрхийн уламжлалт хамгааллын тогтолцоог хангалтгүй болгох эрсдэл дагуулж байна. Энэ нөхцөлд төр нь цахим орчин дахь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх гурван үндсэн үүргээ шинэ нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай болж байна.

Судалгаанд Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиуд — Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн хууль зэрэг холбогдох зохицуулалтыг шинэчилж, олон улсын баримт бичгүүд болох НҮБ-ын “Интернэтэд хүний эрхийг дэмжих, хамгаалах болон эдлэх тухай тогтоол” (2012), Европын Холбооны GDPR, Будапештын конвенцын үзэл санаатай харьцуулан судлан дүгнэлт хийв.

Судалгааны үр дүнгээр Монгол Улсад цахим орчин дахь хүний эрхийн баталгааг хангах эрх зүйн суурь бүрдсэн боловч эрх зүйн уялдаа сул, хяналтын тогтолцоо хангалтгүй, институцийн чадавх, иргэдийн мэдээллийн боловсрол дутмаг зэрэг системийн бэрхшээлүүд байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.

Иймд судалгаагаар дараах бодлогын түвшиний санал, зөвлөмжийг дэвшүүлэв. Үүнд: эрх зүйн шинэчлэл хийх, хүний эрхийн хяналтын хараат бус байгууллага байгуулах, мэдээллийн боловсролыг дээшлүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна. Судалгааны дүгнэлт нь Монгол Улсад цахим орчны хүний эрхийн хамгааллын механизмыг боловсронгуй болгож, цахим шилжилтийн нөхцөлд хүний эрхийн үнэт зүйлийг баталгаажуулахад бодит хувь

<sup>1</sup>Дотоод хэргийн их сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор.

нэмэр оруулах зорилготой юм.

### **Abstract**

*In the digital era, the rapid advancement of information technology has created unprecedented opportunities for the realization and protection of human rights, while simultaneously introducing complex new challenges. Issues such as data breaches, restrictions on freedom of expression, digital discrimination, and the rise of cybercrime threaten to undermine traditional human rights protection mechanisms. Under these conditions, the State must adapt its three fundamental obligations — to respect, protect, and fulfill human rights — to the realities of the digital environment.*

*This study examines the legal framework of Mongolia, including the Constitution of Mongolia, the Law on the Protection of Personal Data (2021), the Cybersecurity Law (2021), the Law on the Rights of the Child, and the Criminal Code, in comparison with key international instruments such as the UN Human Rights Council Resolution “The Promotion, Protection and Enjoyment of Human Rights on the Internet” (2012), the EU General Data Protection Regulation (GDPR), and the Budapest Convention on Cybercrime (2001).*

*The findings reveal that while Mongolia has established the basic legal foundation for ensuring human rights protection in the digital environment, challenges persist in terms of regulatory coherence, institutional capacity, oversight mechanisms, and public digital literacy. These systemic gaps limit the effectiveness of state policies on digital rights.*

*Accordingly, the study proposes several policy-level recommendations: advancing legal reforms, establishing an independent human rights oversight institution, enhancing digital literacy, strengthening public-private partnerships, and expanding international cooperation. The study concludes that strengthening human rights protection mechanisms in Mongolia’s digital environment is essential to aligning digital transformation with the core values of human dignity, freedom, and equality.*

Энэ өгүүлэл [CC BY-NC](#) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



## **1. Танилцуулга**

XXI зуунд өрнөж буй мэдээллийн технологийн хурдацтай хөгжил, цахим шилжилт нь хүн төрөлхтний нийгмийн харилцааны бүхий л хүрээг хамарч, харилцаа холбоо, боловсрол, хөдөлмөрийн зах зээл, төрийн үйлчилгээ, эдийн засгийн бүтцийн шинэчлэл зэрэг олон салбарт гүнзгий нөлөө үзүүлж байна. Энэхүү цахим хувьсгал нь хүний өдөр тутмын амьдралыг илүү хүртээмжтэй, хурдан бөгөөд үр ашигтай болгож буй хэдий ч, нөгөө талаас хүний эрх, эрх чөлөөний баталгаанд урьд өмнө тохиолдож байгаагүй шинэ сорилт, эрсдэлийг бий болгож байна (UN Human Rights Council, 2022).

Манай Улсын иргэдийн цахим хэрэглээ жилээс жилд нэмэгдэж үүнийг даган цахим орчинд үйлдэгдэх гэмт хэргийн гаралт, хохирлын хэмжээ ихсэж, Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, иргэдийн эдийн засаг болон хувийн эрх чөлөөнд ноцтой хор уршиг учруулсаар байна. Монгол Улсын хэмжээнд 2024 онд нийт 44.673 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүний 29.2 хувь буюу 13.361 гэмт хэрэг цахим орчинд үйлдэгдсэн

байна. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн 90.1 хувь буюу 11,771 гэмт хэрэг нь “Цахим Залилах” хэрэг эзэлж байна.

Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийг төрлөөр авч үзэхэд нийт гэмт хэргийн 85.5 хувь нь “Цахим залилах”, 7,5 хувь нь “Кибер орчинд хууль бусаар халдах”, 2.6 хувь нь Мөрийтэй тоглоом зохион байгуулах, 2.4 хувь нь “Худал мэдээлэл тараах”, 0,7 хувь нь “Алдаатай болон андуурсан гүйлгээ”, 1,3 хувь нь бусад төрлийн болох садар самуун сурталчлах, хувь хүний нууцад халдах, задруулах зэрэг гэмт хэргүүд нь ихэвчлэн үйлдэгдэж байна (Б.Соронзонбаатар, 2025).

Технологийн хэт төвлөрөл, мэдээллийн автомат боловсруулалт, хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмын шийдвэр зэрэг нь эрх зүйн хяналтаас давсан шинэ төрлийн цахим эрх зүйн хийдэл (digital legal gap) үүсгэх нөхцөл болж байна.

Эдгээр сорилт нь төрийн үүрэг, хариуцлагыг улам тэлж, цахим орчин дахь хүний эрхийн баталгааг хангах, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, иргэдийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг зөвхөн технологийн биш, харин эрх зүйн ба хүний эрхийн бодлогын нэгдсэн зорилт болгон хувиргажээ. Монгол Улсын хувьд цахим орчин дахь хүний эрхийн хамгааллын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн бодлого, институцийн чадавхыг бэхжүүлэх нь цахим эрин үеийн хамгийн тулгамдсан зорилтын нэг юм.

## 2. Арга зүй

Судалгаанд харьцуулсан эрх зүй болон контент анализыг ашиглаж, НҮБ, ЕХ, Европын Зөвлөлийн зохицуулалтыг Монголын хууль тогтоомжтой харьцуулан, цахим орчин дахь хүний эрхийн зарчим, зохицуулалтын уялдаа, зөрчлийн эрсдэлийг үнэлэхийг зорьсон.

## 3. Судалгааны үр дүн

### Цахим орчин дахь хүний эрхийн онцлог

Цахим эрин үед хүний эрхийн хүрээ улам тэлж, уламжлалт эрхийн ойлголтууд цахим орчны нөхцөлд дахин тодорхойлогдох шаардлага үүсэж байна. Цахим орчны харилцаа нь хил хязгааргүй, виртуал шинжтэй бөгөөд мэдээлэл улс төрийн хил заагийг үл тоон хоромхон зуурт дамжих онцлогтой. Ийнхүү цахим орчны хил хязгааргүй шинж нь тухайн улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хүндрүүлж, эрх зүйн юрисдикцийн хүрээ болон үйлчлэх хязгаарыг тодорхойлох асуудлыг олон улсын түвшинд нарийн төвөгтэй болгож байна (DeNardis, 2020). Иймд цахим орчин дахь хүний эрхийн хамгаалал нь зөвхөн нэг улсын дотоод бодлогоор хязгаарлагдахгүй, харин олон улсын эрх зүйн зохицуулалтын уялдаа, хамтын ажиллагааг шаардах болсон.

Хувийн нууц ба мэдээллийн аюулгүй байдал нь цахим орчин дахь хүний эрхийн хамгийн эмзэг хүрээний нэг юм. Иргэдийн мэдээлэл төр, хувийн хэвшил, платформ үйлчилгээ үзүүлэгч болон хиймэл оюун ухаанд суурилсан системүүдийн хооронд хэт төвлөрөхийн хэрээр мэдээлэл алдагдах, хууль бусаар ашиглагдах, хакердуулах эрсдэл нэмэгдэж байна. Үүний улмаас “мэдээллийн бүрэн бүтэн байдлын эрх” (right to informational integrity) гэх шинэ эрх зүйн ойлголт үүсэж, хүний нэр төр, хувийн

амьдралын халдашгүй байдлыг дижитал орчинд хамгаалах шаардлага улам бүр нэмэгдэж байна (De Hert, 2016).

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх ба контентын хязгаарлалттай холбоотой асуудал нь өнөөгийн дижитал нийгмийн тулгамдсан сэдвийн нэг болоод байна. Нэг талаас цахим сүлжээ нь иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох шинэ орон зайг нээж байгаа бол, нөгөө талаас төрийн хяналт, дижитал платформын алгоритмын шүүлт болон контент автоматаар хязгаарлах механизмууд нь хүний эрх, ялангуяа үзэл бодлын эрх чөлөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй болжээ. “Үндэсний аюулгүй байдал”, “нийгмийн дэг журам” зэрэг нэрийн дор хийгдэж буй зарим зохицуулалт нь цахим хяналт болон мэдээллийн урсгалыг хязгаарлах хэлбэрт шилжих хандлагыг бий болгож байна (UNESCO, 2023).

Цахим эрин үеийн нэгэн шинэ сорилт нь алгоритмын ялгаварлан гадуурхалт юм. “Алгоритмын ялгаварлан гадуурхалт” гэдэг нь хиймэл оюун ухааны системийн өгөгдөл боловсруулах үйл явц дахь хазайлтын улмаас тодорхой бүлгийн хүмүүс шийдвэр гаргалтад тогтмол сөрөг хандлагатай дүгнэгдэх, хохирол амсах эрсдэлтэй болдог үзэгдэл юм (OECD, 2021). Хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргах системүүд (AI-based decision systems) нь өгөгдлийн тэгш бус байдал, эсвэл хазайлттай мэдээллийн боловсруулалт (data bias)-аас үүдэн хүйс, нас, угсаа гарвал, хэл, газар зүйн байршил зэрэг үзүүлэлтээр далд хэлбэрийн ялгаварлал үүсгэх эрсдэлтэй. Ийнхүү өгөгдөлд суурилсан алгоритмын шийдвэр нь хүний эрхийн шинэ зөрчил болох “цахим ялгаварлан гадуурхалт” (digital discrimination)-ыг бий болгож, дижитал шударга ёсны болон тэгш байдлын асуудлыг олон улсын түвшинд хөндөж байна (OECD, 2021).

### **Төрийн үндсэн үүрэг**

Цахим эрин үед хүний эрхийг хамгаалахад төрийн үүрэг улам гүнзгийрч, хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх гэсэн гурван үндсэн чиглэлд илэрч байна. Эдгээр үүрэг нь цахим орчин дахь хүний эрхийн баталгааг хангах төрийн оролцооны онол, эрх зүйн суурь болох ач холбогдолтой.

1. Хүний эрхийг хүндэтгэх үүрэг - Төр өөрийн бүх үйл ажиллагаандаа хүний эрхийн суурь зарчмыг чанд баримтлах ёстой. Цахим хяналт, мэдээлэл цуглуулах, цахим хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцдаа хувь хүний эрх чөлөөнд халдахгүй байх, мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл боловсруулах үйл ажиллагаанд хууль ёсны үндэслэлтэй байх шаардлагыг сахих нь энэхүү үүргийн гол агуулга юм. Энэ хүрээнд төр нь өөрийн цахим бодлого, хяналтын системийг хүний эрхийн стандартад нийцүүлэх замаар иргэдийн итгэлийг хамгаалах ёстой.

2. Хүний эрхийг хамгаалах үүрэг - Төр нь зөвхөн өөрийн үйл ажиллагаанд төдийгүй хувийн хэвшлийн цахим платформ, мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс үүсэх хүний эрхийн зөрчлөөс иргэдийг хамгаалах үүрэгтэй. Энэ хүрээнд цахим үйлчилгээ үзүүлэгчдэд хариуцлагын тогтолцоо бий болгох, хүний эрхийн хяналтын хараат бус институцийг дэмжих, хөндлөнгийн аудит, хяналтын механизмыг нэвтрүүлэх шаардлагатай. Төрийн хамгаалах үүрэг нь цахим орчны зохицуулалтад “зөвшөөрөл, хариуцлага, ил тод байдал” гэсэн гурван зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

3. Хүний эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэг - Төр нь цахим хүртээмжийг тэгш хангах, мэдээллийн боловсрол, дэд бүтэц, интернэтийн хүртээмжийг иргэн бүрт хүргэх замаар цахим тэгш бус байдлыг арилгах ёстой. Энэ нь зөвхөн технологийн асуудал бус, харин нийгмийн шударга ёс, тэгш боломж, оролцооны эрхийн асуудал юм. Төрийн бодлого нь иргэдийн цахим оролцоог дэмжих, мэдээллийн боловсролыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан цахим засаглалын орчныг төлөвшүүлэхэд чиглэгдэх шаардлагатай юм.

### **Олон улсын түвшинд цахим орчин дахь хүний эрхийн хамгааллын баримт бичгүүд**

Олон улсын түвшинд цахим орчин дахь хүний эрхийн хамгаалал нь хүний эрхийн суурь зарчимд тулгуурласан хэд хэдэн чухал баримт бичгээр баталгаажсан байдаг. Эдгээр баримт бичгүүд нь цахим орчныг ердийн амьдралын нэгэн адил хүний эрх, эрх чөлөөний хүрээнд хамаарах орон зай гэж үзэх үзэл санааг төлөвшүүлж, гишүүн орнуудад цахим бодлогоо хүний эрхийн хандлагад нийцүүлэх шаардлагыг дэвшүүлсэн юм.

Юуны өмнө, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн 2012 оны 20/8 дугаар тогтоолоор батлагдсан “Интернэтэд хүний эрхийг дэмжих, хамгаалах болон эдлэх тухай тогтоол” (*The Promotion, Protection and Enjoyment of Human Rights on the Internet*) нь цахим эрин үеийн хүний эрхийн шинэ үзэл санааг тодорхойлсон түүхэн ач холбогдол бүхий баримт бичиг юм. Тус тогтоолд “Интернэт орчинд эдэлж буй хүний эрх, эрх чөлөө нь оффлайн орчинд эдэлж буй эрхтэй ижил түвшинд хамгаалагдах ёстой” гэж заасан бөгөөд цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах, контентын хяналт тогтоох, мэдээллийн урсгалыг хязгаарлах аливаа үйлдлийг хүний эрхийн зөрчил гэж үзэх зарчмыг баталгаажуулсан байна (UN Human Rights Council, 2012).

Энэхүү тунхаглал нь мэдээллийн технологи, цахим засаглал болон олон нийтийн сүлжээний зохицуулалт зэрэг бүх түвшинд хүний эрхийн универсал (普通) хандлагыг баримтлахыг уриалсан баримт бичиг юм. Тус тунхаглалд интернэтэд нэвтрэх, мэдээлэл түгээх, хүлээн авах эрхийг хязгаарлах нь зөвхөн үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, бусдын эрх, нэр төрийг хамгаалах хууль ёсны үндэслэлтэй, хязгаарлагдмал хүрээнд л зөвшөөрөгдөх ёстой гэж тодорхойлсон байдаг. Үүнтэй уялдан “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн 2021 оны 47 дугаар чуулганаар баталсан “Интернэт орчинд хүний эрхийг дэмжих, хамгаалах болон бүрэн эдлэх баталгааны тухай тогтоол” баримт бичигт нь хиймэл оюун ухаан, алгоритмын шийдвэр гаргалт болон автомат хяналтын системийн хэрэглээнд хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ (UN Human Rights Council, 2021) хийхийг гишүүн орнуудад зөвлөсөн байна.

Эдгээр баримт бичгүүд нь нийтлэгээр “цахим эрх” (*digital rights*) хэмээх ойлголтыг тодорхойлон төлөвшүүлж, цахим орчны бодлого, хууль тогтоомжийг хүний эрхийн суурь зарчимд нийцүүлэх олон улсын эрх зүйн чиг хандлагын үндэс суурийг тавьсан юм (Human Rights Council, 2021). Монгол Улсын хувьд энэхүү тунхаглалын үзэл санааг үндэслэн мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээллийн хамгаалал, цахим хүртээмж, нээлттэй өгөгдлийн бодлого зэрэг салбарт хүний эрхийн хандлагад суурилсан цахим бодлого боловсруулах шаардлагатай байна.

### **Европын Холбооны Ерөнхий мэдээлэл хамгаалах журам (GDPR)**

Европын Холбооны Ерөнхий мэдээлэл хамгаалах журам (General Data Protection Regulation — GDPR) нь 2016 онд батлагдаж, 2018 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд дэлхий дахинд хувийн мэдээллийн хамгааллын хамгийн дэвшилтэт эрх зүйн тогтолцооны нэг хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн байна. Энэхүү журам нь мэдээлэл боловсруулах үйл ажиллагаанд хүний эрхийн хандлагыг үндсэн зарчим болгон тусгаж, мэдээллийн эзний эрхийг төр, хувийн хэвшил болон цахим үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын өмнө тэнцвэртэй, үр нөлөөтэйгөөр хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлсэн юм (European Parliament and Council, 2016).

GDPR нь мэдээлэл хамгааллын долоон үндсэн зарчмыг тодорхойлсон бөгөөд үүнд: хууль ёсны байдал, шударга байдал ба ил тод байдал; зорилгын хязгаарлалт; өгөгдлийн хязгаарлалт; нарийвчлал; хадгалалтын хугацааны хязгаарлалт; нууцлал ба бүрэн бүтэн байдал; хариуцлагын зарчим багтдаг. Эдгээр зарчмыг мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, дамжуулах бүх шатанд чанд мөрдөхийг байгууллагуудаас шаардаж, мэдээлэл ашиглалтад ил тод байдал ба хариуцлагыг эрх зүйн үндсэн шаардлага болгон тогтоосон байна.

Түүнчлэн энэхүү журамд иргэний “мартагдах эрх” (*right to be forgotten*) буюу хувь хүн өөрийн мэдээллийг цахим орчноос устгуулах, дахин ашиглуулахаас татгалзах эрхийг хуульчилсан нь мэдээллийн нууцлал, нэр төрийн халдашгүй байдал, мэдээлэлд эзэн байх эрхийг шинэ түвшинд авчирсан гэж судлаачид үздэг (European Parliament and Council, 2016).

GDPR-ийн үзэл санаа нь Европын Холбооны хүрээнээс хальж, дэлхийн хэмжээнд хувийн мэдээллийн хамгааллын жишиг стандарт болон төлөвшжээ. Үүний нөлөөгөөр АНУ, Канад, Япон, БНСУ зэрэг хөгжингүй орнууд, мөн олон хөгжиж буй улс орнууд мэдээлэл хамгааллын хууль тогтоомж, бодлогын шинэчлэлээ GDPR-ийн зарчимд нийцүүлэх чиглэлд хөгжүүлж байна.

Монгол Улсын хувьд 2021 онд батлагдсан “Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль” нь GDPR-ийн үндсэн зарчмуудыг дотоод эрх зүйн орчинд нэвтрүүлсэн анхны алхам болсон (European Parliament and Council, 2016). Гэсэн хэдий ч уг хуулийн хэрэгжилтийн хяналт, хариуцлагын тогтолцоо сул, хараат бус хяналтын байгууллагын бүрэн эрх хангалтгүй хэвээр байна. Иймээс Монгол Улс цаашид GDPR-ийн хариуцлагын тогтолцоо, хараат бус хяналтын байгууллагын загварыг нутагшуулах замаар мэдээллийн хамгааллын эрх зүйн тогтолцоогоо боловсронгуй болгох шаардлагатай юм.

### **Будапештын конвенц ба Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагаа**

Будапештын конвенц, албан ёсны нэршлээр Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенц (*Convention on Cybercrime, 2001*) нь кибер орон зайн аюулгүй байдлыг хангах, цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр батлагдсан анхны олон улсын эрх зүйн баримт бичиг юм. Энэхүү конвенцыг Европын Зөвлөлөөс баталсан бөгөөд өдгөө дэлхийн 60 гаруй улс нэгдэн орсон, гишүүн орнуудын дунд өргөн хүрээнд хэрэгжиж буй олон улсын эрх зүйн хамтын ажиллагааны үндсэн гэрээ болон хөгжсөн байна (Council of Europe, 2001).

Будапештын конвенцын үндсэн зорилго нь кибер гэмт хэрэгтэй тэмцэхэд гишүүн орнуудын хууль тогтоомж, мөрдөн шалгах болон нотлох баримт солилцох үйл ажиллагааг уялдуулах замаар нэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршдог. Энэ хүрээнд гишүүн орнууд мэдээллийн сүлжээ, сервер, цахим нотлох баримттай холбоотой ажиллагаанд харилцан туслалцах, мэдээлэл солилцооны шуурхай механизмыг хөгжүүлэх үүрэгтэй.

Конвенцын 2–13 дугаар зүйлүүдэд кибер гэмт хэргийн үндсэн хэлбэрүүд болох хууль бусаар мэдээллийн системд нэвтрэх, өгөгдөл устгах, мэдээлэл өөрчлөх, цахим залилан хийх, зохиогчийн эрхийн зөрчил гаргах зэрэг үйлдлийг тодорхойлж, эдгээрийг гишүүн орнууд дотоодын хууль тогтоомждоо гэмт хэрэгт тооцох үүрэгтэй гэж заасан.

Энэхүү зохицуулалт нь кибер гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хариуцлага тооцох үйл явцад олон улсын түвшний нэгдсэн ойлголт, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгосон гэж үздэг (Council of Europe, 2001).

Будапештын конвенц нь зөвхөн кибер гэмт хэрэгтэй тэмцэхэд бус, кибер аюулгүй байдлын олон улсын соёлыг төлөвшүүлэх, мэдээллийн технологийн хэрэглээнд хүний эрхийн баталгааг хадгалах эрх зүйн жишиг тогтоосноороо онцлог юм. Энэ баримт бичиг нь “Интернэт бол дэлхийн нийтийн орон зай” гэсэн зарчмыг хууль зүйн түвшинд баталгаажуулж, хил дамнасан мөрдөн шалгах ажиллагаа, нотлох баримт солилцох хамтын ажиллагааг үр дүнтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улс 2021 онд уг конвенцод нэгдэн орсноор кибер гэмт хэрэгтэй тэмцэх, нотлох баримт солилцох, мөрдөн шалгах хамтын ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг бүрдүүлсэн боловч хэрэгжилтийн түвшинд техник, мэргэжлийн чадавх, хүний эрхийн хяналтын механизм хангалтгүй байгаа нь сорилт хэвээр байна.

Эдгээр олон улсын баримт бичгүүд нь цахим орчин дахь хүний эрхийн хамгааллын суурь зарчим, үнэт зүйлийг тодорхойлж, дэлхий дахины хэмжээнд цахим эрхийн эрх зүйн тогтолцоо бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан. Түүнчлэн гишүүн орнуудад цахим эрхийн хамгааллыг хуульчлах, хараат бус хяналтын институцийг байгуулах, технологийн бодлогыг хүний эрхийн үнэт зүйлтэй уялдуулах тодорхой чиглэл, стандартыг тогтоож өгсөн.

Монгол Улсын хувьд эдгээр баримт бичгийн үзэл санааг үндэсний хууль тогтоомж, бодлого, институцийн түвшинд системтэйгээр уялдуулах нь цахим шилжилтийн эринд хүний эрхийн баталгааг бэхжүүлэх стратегийн ач холбогдолтой зорилт юм. Энэ нь зөвхөн хууль эрх зүйн шинэчлэл төдий бус, төрийн бодлого, цахим аюулгүй байдал, иргэдийн мэдээллийн соёл, оролцоог уялдуулах цогц үйл явц байх ёстой гэж дүгнэж байна.

### **Эрх зүйн зохицуулалт: Цахим орчин дахь хүний эрхийн баталгааны үндэс**

Цахим орчин дахь хүний эрхийн баталгааг хангах эрх зүйн тогтолцооны суурь нь Монгол Улсын Үндсэн хууль бөгөөд энэ нь төрөөс хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх гурван үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн баталгаа болж өгдөг.

Үндсэн хуулийн хүрээнд хүний эрхийн баталгаа

Монгол Улсын Үндсэн хуулийн (1992) 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт “... *итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван*

жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй” гэж заасан нь орчин үеийн цахим харилцааны нөхцөлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн үндэс болж байна. Энэ нь цахим орчинд иргэдийн үзэл бодол, оролцоог хамгаалах төрийн үүргийг илэрхийлдэг.

Мөн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан нь иргэний хувийн мэдээлэлд халдашгүй байх, мэдээлэлд хандах эрхийг баталгаажуулсан зохицуулалт юм. Энэхүү заалт нь цахим орчинд мэдээллийн ил тод байдал ба хувийн нууцын хамгааллын тэнцвэрийг хангах чухал үндэс болдог.

Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүрэгтэй” гэж заасан нь төрийн үүргийг тодорхойлсон суурь зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, төр нь цахим орчин дахь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх механизмыг бүрдүүлэх үүрэг хүлээдэг.

Гэвч үзэл бодлын эрх чөлөө нь хязгааргүй биш бөгөөд бусдын нэр төр, алдар хүнд, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хууль ёсны хүрээнд хязгаарлаж болно. Энэ хүрээнд Монгол Улсын Эрүүгийн хууль-д “худал мэдээлэл тараах” (13.14 дүгээр зүйл) гэмт хэргийг тусгайлан зүйлчилсэн нь цахим орчин дахь үг хэлэх эрх ба хариуцлагын тэнцвэрийг хангах зорилготой зохицуулалт юм.

Хүний хувийн мэдээлэл ба цахим орчин дахь аюулгүй байдал эрх зүйн орчин

Монгол Улсын “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль” (2021) нь мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг мэдээллийн эзний зөвшөөрөлтэй уялдуулсан нь Европын Холбооны GDPR-ийн үзэл баримтлалтай дүйцэхүйц дэвшил юм. Тус хуулийн 8.1 дэх хэсэгт “мэдээлэл хариуцагч нь мэдээллийг боловсруулахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авна” гэж заасан нь мэдээлэл эзэмшигчийн эрхийг хууль зүйн хүрээнд хамгаалах чухал баталгаа болж, Монгол Улсад хувийн мэдээлэл хамгаалах соёлыг төлөвшүүлэх эхлэлийг тавьжээ.

Харин “Кибер аюулгүй байдлын тухай хууль” (2021) нь цахим орон зайн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах эрх зүйн үндсийг тогтоосон. Энэхүү хууль нь төр, хувийн хэвшлийн цахим аюулгүй байдлын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон боловч хүний эрхийн баталгааг хангах талаасаа зарим тодорхойгүй зохицуулалттай, төрийн хяналт хэтрэх эрсдэлтэй гэж үздэг. Иймд хуулийг хэрэгжүүлэхдээ хүний эрхийн хяналтын тэнцвэртэй механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн (2015) 26 дугаар бүлэгт “цахим орчинд хууль бусаар халдах”, “программ хангамж, техник хэрэгсэл бэлтгэх, ашиглах, тараах” зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь иргэдийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн баталгаа юм. Гэвч практикт эдгээр заалтуудын хэрэгжилт хангалтгүй, мөрдөн шалгах ажиллагаанд техникийн болон хүний нөөцийн дутагдал зэрэг хүндрэлүүд байна.

Хүүхдийн эрхийн хамгаалал ба олон улсын гэрээ конвенцын уялдаа

Цахим орчны нөлөөнд хамгийн эмзэг бүлэг болох хүүхдийн эрхийг хамгаалахад Монгол Улсын “Хүүхдийн эрхийн тухай хууль”-ийн (2016) 7.3 дугаар зүйлд “хүүхэд хувийн мэдээлэл, орон байр, гэр бүлийн амьдралын халдашгүй байдлаа хамгаалуулах эрхтэй” гэж заасан нь цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах төрийн үндсэн үүрэг хэмээн тодорхойлсон.

Энэхүү зохицуулалт нь Хүүхдийн эрхийн тухай конвенцын (1989) 13 дугаар зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын (1976) 19 дүгээр зүйлд заасан үзэл санаатай уялдаж байна. Эдгээр баримт бичгүүдэд хүн бүр, тэр дундаа хүүхэд, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж заасан бөгөөд энэ эрх нь цахим орчинд ч адилхан хүчин төгөлдөр үйлчилнэ. Төрөөс энэхүү эрхийг хэрэгжүүлэхдээ хууль ёсны, ардчиллын шаардлагад нийцсэн, зайлшгүй тохиолдолд хязгаарлалт тавих зарчмыг чанд баримтлах ёстой.

Монгол Улсын эрх зүйн тогтолцоо нь цахим орчин дахь хүний эрхийн хамгааллын суурь нөхцөлийг бүрдүүлсэн ч, хуулийн уялдаа сул, хэрэгжилтийн хяналт хангалтгүй, институцийн чадавх дутмаг, иргэдийн мэдээллийн боловсрол хязгаарлагдмал байгаа нь тогтолцооны гол хүндрэлүүдийн нэг хэвээр байна. Иймээс эрх зүйн орчныг олон улсын стандарттай уялдуулан шинэчлэх, хүний эрхийн хяналтын хараат бус байгууллагын чадавхыг бэхжүүлэх, цахим боловсролыг дэмжих, төр–хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.

### **Монгол Улсын эрх зүйн орчны тулгамдсан асуудал**

Монгол Улсад цахим орчин дахь хүний эрхийн хамгааллын эрх зүйн үндэс бүрдсэн хэдий ч, хэрэгжилтийн түвшинд дараах гол хүндрэлүүд ажиглагдаж байна. Эдгээр асуудлууд нь төрийн бодлогын үр нөлөө, хүний эрхийн баталгааны чанарт нөлөөлж, цахим шилжилтийн тогтвортой байдлыг сулруулж байна.

#### **1. Эрх зүйн зохицуулалтын хийдэл ба хяналтын сул байдал**

Монгол Улсад цахим орчныг зохицуулах хууль эрх зүйн орчин харьцангуй бүрдсэн боловч, хуулиудын уялдаа холбоо сул, давхардал, хийдэл байсаар байна. Төрийн байгууллагуудын мэдээлэл цуглуулах, ашиглах, дамжуулах үйл ажиллагаанд ил тод, хараат бус хяналтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна. Тухайлбал, “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль” болон “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийн түвшинд мэдээлэл хариуцагчдын хариуцлага тодорхой бус, хяналтын байгууллагын бүрэн эрх хооронд давхцаж байгаа нь мэдээллийн эзний эрхийг хамгаалах үр нөлөөг бууруулж байна. Үүнээс гадна төрийн байгууллагын мэдээллийн төвлөрсөн системийн хяналт, өгөгдлийн удирдлагын ил тод байдал сул байгаа нь хүний эрхийн зөрчлийн шинэ эрсдэл үүсгэх нөхцөл болж байна.

#### **2. Институцийн чадавхын хомсдол ба хүний нөөцийн дутагдал**

Хүний эрхийн хамгаалал болон цахим аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт нь институцийн чадавхаас шууд хамааралтай. Монгол Улсад кибер аюулгүй байдал, мэдээллийн хамгаалал, хүний эрхийн хяналтын чиглэлээр мэргэшсэн хүний нөөц хангалтгүй, төрийн болон хяналтын байгууллагын дотоод зохион байгуулалт сул хэвээр байна.

Жишээлбэл, Хүний эрхийн Үндэсний комисс болон Харилцаа холбооны зохицуулах хороо, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв зэрэг байгууллагуудын чиг үүрэг хооронд уялдаа муу, хариуцлагын хуваарилалт тодорхой бус байгаа нь бодлогын хэрэгжилтийг сааруулж байна. Институцийн түвшинд хүний эрхийн хяналтыг технологийн дүн шинжилгээ, дата менежменттэй хослуулах чадвар сул байгаагаас бодлогын үр дүнг хэмжих, зөрчилд хариу арга хэмжээ авах механизм бүрэн хөгжөөгүй байна.

### 3. Цахим тэгш бус байдал ба хүртээмжийн зөрүү

Цахим шилжилтийн гол тулгуур нь дижитал хүртээмж бөгөөд энэ нь хүний эрхийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх үндэс юм. Гэвч Монгол Улсад хот, хөдөөгийн хооронд цахим дэд бүтэц, интернэтийн хурд, чанар, цахим үйлчилгээний хүртээмжийн ялгаа их байна. Үүний улмаас иргэдийн мэдээлэлд хандах, цахим орчинд оролцох эрхийн тэгш байдал алдагдаж байна.

Мөн дижитал үйлчилгээний төвлөрөл нь тодорхой нийгмийн бүлгийг (жишээлбэл, өндөр настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, алслагдсан нутгийн иргэд) цахим үйлчилгээний гадна үлдээх эрсдэл дагуулж байна. Энэ нь дижитал эрхийн бодит хэрэгжилтэд саад болж, дижитал ялгаварлал буюу “мэдээлэлд суурилсан тэгш бус байдал”-ын асуудлыг гүнзгийрүүлж байна.

### 4. Иргэдийн мэдээллийн боловсрол ба цахим соёлын төлөвшлийн сул байдал

Иргэд цахим орчин дахь өөрийн эрх, үүргийг бүрэн ойлгохгүй, мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээллээ хамгаалах талаарх мэдлэг, дадал сул байгаа нь хүний эрхийн зөрчилд хүргэж байна. Мэдээллийн үнэн бодит байдалд дүн шинжилгээ хийх чадвар муу, хуурамч мэдээлэлд итгэх, хувийн мэдээллээ задруулах зэрэг үзэгдэл түгээмэл байна.

Энэ нь зөвхөн боловсролын асуудал бус, иргэний хариуцлага, цахим ёс зүйн соёл, дижитал оролцооны боловсрол-ын түвшинг илтгэж байгаа юм. Иймээс төрийн болон боловсролын байгууллагуудын түвшинд мэдээллийн боловсрол, кибер соёлын сургалтыг системтэйгээр нэвтрүүлэх шаардлагатай байна.

Дээрх асуудлууд нь Монгол Улсад цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах тогтолцоог бүрэн утгаар нь хэрэгжүүлэхэд саад болж буй үндсэн бэрхшээлүүд юм. Энэ нь зөвхөн хууль эрх зүйн хүрээний асуудал биш, харин ардчилсан засаглал, мэдээллийн аюулгүй байдал, технологийн ёс зүй, боловсролын бодлого зэрэг олон талт хүчин зүйлийн огтлолцолд орших цогц бодлогын асуудал юм.

Төр нь хүний эрхийн хамгааллыг кибер аюулгүй байдлын техник бодлогоос тусгаарлах бус, харин эрх зүйн хяналт, технологийн шийдэл, хүний эрхийн боловсрол, олон улсын хамтын ажиллагааг уялдуулсан цогц тогтолцоо болгон хөгжүүлэх шаардлагатай байна. Ийм шинэчлэл хийгдсэнээр Монгол Улс цахим орчин дахь хүний эрхийн баталгааг бодитойгоор хангаж, дижитал шилжилтийн эринд хүний эрхийн үнэт зүйлийг хамгаалсан тогтвортой эрх зүйн орчныг бүрдүүлэх боломжтой юм.

#### 4. Дүгнэлт

Дижитал эрин үед хүний эрхийн баталгааг хангах асуудал улам бүр олон талт, нарийн төвөгтэй шинжтэй болж байна. Технологийн хурдацтай хөгжил нь мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувийн нууц, мэдээллийн аюулгүй байдал, үзэл бодлын эрх чөлөө, цахим ялгаварлан гадуурхалт зэрэг хүний эрхийн шинэ хэлбэрийн зөрчил, эрсдэлийг бий болгож байна.

Монгол Улсын эрх зүйн тогтолцоо Үндсэн хуулиар хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, холбогдох салбар хуулиудаар (жишээлбэл: Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Эрүүгийн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль) цахим орчин дахь хүний эрхийн хамгааллын эрх зүйн үндэс суурийг бүрдүүлсэн хэдий ч, эдгээрийн хэрэгжилт, уялдаа холбоо болон хяналтын тогтолцооны хувьд тодорхой сул талууд байсаар байна.

Хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг нь зөвхөн хууль тогтоомж батлах төдий бус, эрх зүйн орчны бодит хэрэгжилтийг хангах, институцийн чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх зэрэг цогц бодлогын арга хэмжээг шаардаж байна. Монгол Улсын цахим орчны бодлого хүний эрхийн үзэл санаанд тулгуурласан, урьдчилан сэргийлэх, боловсрол, хяналт, хариуцлагын тэнцвэртэй системд суурилсан байх шаардлагатай юм.

Өнөөгийн нөхцөлд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа болон “shared responsibility” буюу хамтарсан хариуцлагын зарчим-д суурилсан цахим засаглал нь хүний эрхийг дижитал шилжилтийн бодлого, хөгжлийн хөтөлбөртэй уялдуулах стратегийн шинэ чиг хандлага болж байна.

Монгол Улс энэхүү сорилтыг оновчтой шийдвэрлэж чадвал дижитал шилжилтийн эерэг нөлөөг хүний эрхийн хамгаалалттай уялдуулан, ардчилсан, мэдээллийн аюулгүй, хүний эрхэд суурилсан цахим нийгмийн хөгжлийн загвар улс болох бүрэн чадамжтай юм.

#### Санал, зөвлөмж

##### 1. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох

- Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг GDPR-ийн зарчимд нийцүүлэн шинэчилж, мэдээллийн эзний эрхийн хамгааллыг бэхжүүлэх;

- Кибер аюулгүй байдлын тухай хууль-д хүний эрхийн баталгааг тусгай бүлгээр тусгаж, төрийн байгууллагын мэдээлэл цуглуулах, ашиглах үйл ажиллагаанд бие даасан хараат бус хяналтын тогтолцоо нэвтрүүлэх;

- Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх ба хариуцлагын тэнцвэрийг хангах цахим эрхийн бодлогын баримт бичиг (Digital Rights Framework) боловсруулах.

##### 2. Институцийн чадавхыг бэхжүүлж, мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх

- Цахим орчин дахь хүний эрхийн асуудлаар ажиллах төрийн болон төрийн бус байгууллагын мэргэшсэн судалгааны төв, сургалтын нэгжийг дэмжих;

- Хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан “цахим эрх зүй” болон “мэдээллийн аюулгүй байдал”-ын сургалтыг тогтмолжуулж, чадавхыг сайжруулах;

- Шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагын түвшинд дижитал нотлох баримт, цахим гэмт хэргийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн тогтолцоог хөгжүүлэх.

### 3. Цахим боловсрол ба иргэдийн оролцоог дэмжих

- Иргэдийн мэдээллийн боловсролыг сайжруулах үндэсний хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлж, ерөнхий боловсролын болон дээд боловсролын хөтөлбөрт “цахим ёс зүй ба хүний эрх”-ийн сургалтыг оруулах;

- Цахим орчны хэрэглээ, мэдээлэл түгээх, үнэлэх, шалгах чадварыг дээшлүүлэх “Digital Citizenship” боловсролын хөтөлбөр нэвтрүүлэх;

- Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан цахим орчны аюулгүй байдлын сургалтыг тогтмолжуулж, эцэг эхийн хяналт, оролцооны эрх зүйн механизмыг боловсронгуй болгох.

### 4. Олон улсын хамтын ажиллагаа ба бүс нутгийн түншлэл

- Монгол Улс Будапештын конвенц-ийн хэрэгжилтийн хүрээнд бүс нутгийн цахим аюулгүй байдлын төв байгуулах санаачилга гаргах;

- “Нэгдсэн Үндэстний Байгууллага, Зүүн Өмнөд Азийн Улсуудын Холбоо болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага зэрэг олон улсын байгууллагуудын хүний эрх ба дижитал технологийн чиглэлд идэвхтэй оролцож, хамтарсан судалгаа, туршлага солилцох хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

- Гадаадын дижитал платформуудтай хүний эрхийн талаарх хамтарсан хяналт, ил тод байдлын тогтолцоо бий болгох.

### 5. Төр-хувийн хэвшлийн түншлэл ба дотоод зохицуулалтын тогтолцоо

- Үндэсний хэмжээний дижитал платформууд болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хүрээнд хүний эрхэд суурилсан дотоод бодлого, ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх;

- Хувийн хэвшлийн оролцоотой “Responsible Tech Initiative” хөтөлбөр хэрэгжүүлж, хүний эрхэд нийцсэн технологийн инновацыг дэмжих;

- Хиймэл оюун ухаанд суурилсан системүүдийн ил тод байдал, хариуцлагын стандарт тогтоох AI Ethics Charter боловсруулах.

### 6. Хүний эрхийн хараат бус хяналтын механизмыг бэхжүүлэх

- Цахим орчны хүний эрхийн зөрчил, маргааныг судлах, зөвлөх, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий “Цахим эрхийн зөвлөмжийн платформ” (Digital Rights Platform) байгуулах боломжийг судлах.

Цахим орчин дахь хүний эрхийн баталгаа нь зөвхөн мэдээллийн аюулгүй байдлын асуудал биш, харин ардчиллын үнэт зүйл, хүний нэр төр, тэгш боломж, шударга ёсны

баталгаа юм. Технологийн хөгжлийг хүний эрхийн зарчимтай уялдуулах нь төрийн нэг талын үүрэг бус, харин нийгмийн бүх түвшний хамтын оролцоо, ёс зүй, боловсрол, хариуцлагын асуудал юм.

Монгол Улс хүний эрхийн соёлыг цахим шилжилтийн бодлого, дижитал технологийн хөгжлийн чиглэлтэй уялдуулж чадвал, цахим орчны сорилтыг боломж болгон хувиргаж, ардчилсан, мэдээллийн аюулгүй, хүний эрхэд суурилсан цахим нийгмийн хөгжлийн загвар улс болох бүрэн боломжтой юм.

## 5. Эх сурвалж

### Монгол Улсын хууль тогтоомж, бусад эх сурвалж

- Монгол Улсын Үндсэн хууль. (1992). Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1.
- Хүний Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль. (2021). Төрийн мэдээлэл эмхэтгэл, №34.
- Кибер аюулгүй байдлын тухай хууль. (2021). Төрийн мэдээлэл эмхэтгэл, №38.
- Монгол Улсын Эрүүгийн хууль. (2016). Төрийн мэдээлэл эмхэтгэл, №21.
- Хүүхдийн эрхийн тухай хууль. (2016). Төрийн мэдээлэл эмхэтгэл, №7.
- Б.Соронзонбаатар. Кибер орчин дахь нөхцөл байдал. Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил: Онол, чиг хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2025

### Гадаад хэл дээрх эх сурвалж

- Council of Europe. (2001). *Convention on Cybercrime (Budapest Convention)*. European Treaty Series No. 185. Council of Europe. Retrieved from <https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treatynum=185>
- European Parliament and Council. (2016). *Regulation (EU) 2016/679: General Data Protection Regulation (GDPR)*. Official Journal of the European Union, L119, 1–88.
- United Nations Human Rights Council. (2012). *The promotion, protection and enjoyment of human rights on the Internet (A/HRC/RES/20/8)*. United Nations. Retrieved from <https://www.ohchr.org>
- United Nations Human Rights Council. (2021). *Guiding principles on human rights and the digital age*. United Nations.
- UNESCO. (2023). *World Trends in Freedom of Expression and Media Development: Global Report 2023*. Paris: UNESCO Publishing.
- OECD. (2021). *Artificial Intelligence and the Future of Work*. OECD Publishing. <https://doi.org/10.1787/7c193c3b-en>
- DeNardis, L. (2020). *The Internet in Everything: Freedom and Security in a World with No Off Switch*. Yale University Press.
- Bygrave, L. A. (2017). *Data Privacy Law: An International Perspective*. Oxford University Press.
- Floridi, L. (2014). *The Fourth Revolution: How the Infosphere Is Reshaping Human Reality*. Oxford University Press.
- Tufekci, Z. (2015). *Algorithmic harms beyond Facebook and Google: Emergent challenges of computational agency*. *Colorado Technology Law Journal*, 13(1), 203–218.
- Human Rights Watch. (2022). *World Report 2022: Events of 2021*. Human Rights Watch.
- Freedom House. (2023). *Freedom on the Net 2023: The Repressive Power of Artificial Intelligence*. Washington, D.C.
- National Human Rights Commission of Mongolia. (2022). *Annual Report on the Situation of Human Rights and Freedoms in Mongolia*. Ulaanbaatar.